

“Програм хангамжийн архитектур” хичээлийн дасгал

Хаврын семестер 2012

Дасгал №1

Дасгалын ажлын зохион байгуулалт
Баасан гариг бүр 15:25-17:50

Даалгавар №1 (Өгөгдлийн зохиомж)

Номин электроникс компани танд интерактив агуулах удирдах систем бүтээх даалгаврыг өгчээ. Тэрхүү систем нь номингийн салбар дэлгүүрүүдэд бараа нийлүүлэх болон нөөцийг нь тодорхойлоход хэрэглэгдэнэ.

Даалгавар олгогч дараах зүйлсийг тодорхой шаарджээ.

- Дэлгүүрүүдийн агуулахад буй бараанууд (item) тус өөрийн код (id) ба төрөлтэй (type)
- Янз бүрийн төрөл (type) байж болох ба өөрийн гэсэн тодорхойлогч нэр ба хэмжээтэй. (Өндөр, Өргөн, Зузаан, Жин)
- Барааны төрөл бүрд нэг эсвэл хэд хэдэн нийлүүлэгч (supplier) байж болох ба нийлүүлэгч бүх хэд хэдэн төрлийн бараа нийлүүлж болно.
- Нийлүүлэгч бүр өөрийн гэсэн нэртэй.

Та дээрх даалгаварт тохирох өгөгдлийн зохиомжийг Entity-Relationship-Diagramms (ER-Diagramm) болон UML класс диаграм хэлбэрээр гаргана уу. Мөн энэ 2 диаграммын ялгааг тодорхойлно уу.

Даалгавар №2 (Шаардлагын тодорхойлолтыг гүйцээх)

Нэгдүгээр даалгаврын шаардлагыг функционал өнцгөөс нь харж гүйцээнэ үү. (Агуулах, Шалгалт, Шинэ төрөл нэмэх, шинэ нийлүүлэгч нэмэх гэх мэт.)

Даалгавар №3 (Үйл ажиллагааны зохиомж)

Хоёрдугаар даалгавраас гарсан функцүүдээс үйл ажиллагааны (functional design) зохиомжийг гаргана уу. Үүнд та өгөгдлийн урсгалын диаграмм буюу (DFD) ашиглана уу.

Даалгавар №4 (ER диаграмм ба өгөгдлийн урсгалын диаграмм)

Эхний болон гуравдугаар даалгавраас гарсан загваруудын тохирох элементийн төрлүүдийг харьцуулан үзүүлнэ үү. Өөрөөр хэлбэл ER ба DFD диаграммуудын тохирох элементүүдийг харьцуулан үзүүлнэ үү.